



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/619

Ховд

Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтуудыг үндэслэн Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь

1. Аймгийн Засаг даргын 2008 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 75 дугаар захирамжаар гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэдийн хэлцлийг харгалзан Жаргалант сумын Наран багийн 01-02 тоот, 525,0 м² хэмжээтэй, 2625000 төгрөгийн үнэ бүхий газрыг иргэн Надмидын Алтангэрэлд үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өмчлүүлсүгэй.

2. Дээрх нэр бүхий иргэдэд шилжүүлсэн газарт хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга /Э.Дөлбадрал/, Улсын бүртгэлийн хэлтсийн дарга /Хоролсүрэн/ нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2008 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 75 дугаар захирамжийн 54 дэх заалтын Д.Эрдэнэсүвд, А.Бумбаяр, А.Бат-амгалан, А.Өнөрмаа нарт холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгосугай.


ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/619 Ch
02 2803

Аймгийн Засаг даргын 2020 оны
10 дугаар сарын 20-ны өдрийн А/619 дүгээр
захирамжийн хавсралт



ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХЭЭ НЭГ ГИШҮҮНДЭЭ
ҮНЭ ТӨЛБӨРГҮЙГЭЭР ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

Овог нэр	Хаяг	Газрын хэмжээ /м2/	Газар өмчилж авсан захирамжийн огноо	Дугаар	Хавсралтанд орсон дугаар
Д.Эрдэнэсүвд А.Бумбаяр А.Бат-Амгалан А.Өнөрмаа	Наран баг 1-2 тоот	525,0	2008-03-19	75	54